



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Прокурорын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/50/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: bayanulgii@audit.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382

Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710

Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Х.Еркебулан

Утас: 70423073

Цахим хаяг: akon_erka@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	6
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.12	Шилэн дансны мэдээлэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Прокурорын газрын тамгын хэлтсийн дарга Р.Гүлбарим танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Прокурорын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Прокурорын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01-р сарын 23-наас 2018 оны 01-р сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 01-р сарын 29-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Х.Еркебулан хариуцаж хэрэгжүүлэв.

Прокурорын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 01-р сарын 09-ний өдөр аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 01-р сарын 09-ний өдөр-ны өдрийн №01/20–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Прокурорын газар “Хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих” эрхэм зорилгын дор Улсын Ерөнхий Прокурорын газрын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Прокурорын газар дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Прокурорын газар “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Прокурорын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Прокурорын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Прокурорын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Прокурорын газрын санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 15 асуудал эрсдэл өндөр, гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 45 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 15 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн орлогыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Прокурорын газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого бөгөөд түүний 2 хувь 8.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь дотоод хяналтын үнэлгээ сайн байгаатай холбоотой.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 15 эрсдэлтэй асуудалд 15 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 50 хувь буюу 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	0	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
Дүн		0	0.0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар материаллаг алдаа зөрчил илрээгүй болно.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага өгөх зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хариуцлагаа тооцуулах санал байхгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх зөрчилтэй асуудал илэрээгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Прокурорын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 412,2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	412.2	412.2	0.009%	0.03
1.1	Урсгал зардал	412.2	412.2	0.009%	0.03
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	412.2	412.2	0.009%	0.03
2.1	Улсын төсвөөс санхүүжих	412.2	412.2	0.009%	0.03
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Прокурорын газар нь 2017 онд 412.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, улсын төсвөөс 412.3 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвтөө

багтаан үйл ажиллагаа явуулжээ.Төсвийн гүйцэтгэл өмнөх оноос нэмэгдсэн нь цалин нэмэгдсэнтэй холбоотой.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 0,6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч урсгал зардалд зарцуулсан байна.Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Прокурорын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 3 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 17 горим сорил хэрэгжүүлсэн ба алдаа зөрчил илрээгүй болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Прокурорын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Прокурорын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчил байхгүй болно.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.15 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>334332.19</u>	<u>2263415.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	38732.19	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	38732.19	0.00
3121	Төгрөг	38732.19	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	38732.19	
33	АВЛАГА	0.00	57465.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	57465.00
35	БАРАА МАТЕРИАЛ	295600.00	2205950.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	69600.00	1343350.00
354	Хангамжийн материал	226000.00	862600.00
35410	Бичиг хэргийн материал	36000.00	647000.00
35420	Аж ахуйн материал	190000.00	215600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1001606257.36</u>	<u>970690030.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1001606257.36	970690030.83
392	Биет хөрөнгө	1001573257.36	970690030.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	998022657.00	980041857.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38814831.00	-37168062.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67900000.00	67900000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-53754166.92	-65070833.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38729822.00	26339430.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31377224.63	-21220142.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31439469.72	31312348.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11597968.81	-12470066.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	4577400.00	0.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4577400.00	0.00
39217	Ном	1025500.00	1025500.00
393	Биет бус хөрөнгө	33000.00	0.00
39301	Програм хангамж	715000.00	715000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-682000.00	-715000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1001940589.55</u>	<u>972953445.83</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1001940589.55</u>	<u>972953445.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1001940589.55	972953445.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	192932674.00	192932674.00
51101	Өмч: - төрийн	192932674.00	192932674.00
512	Хуримтлагдсан үр дүн	571602003.55	542614859.83
51210	Өмнөх үеийн үр дүн	571602003.55	571602003.55
51220	Тайлант үеийн үр дүн		-28987143.72

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	237405912.00	237405912.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1001940589.55</u>	<u>972953445.83</u>

2.16 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	287007675.41	416582300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11317175.41	3749000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11317175.41	3749000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11317163.72	3749000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11317163.72	3749000.00
120009	Бусад орлого	11.69	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275690500.00	412833300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275690500.00	412233300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275690500.00	412233300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	600000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	600000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	319048552.27	445569443.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319048552.27	445569443.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318648532.27	445569355.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200491656.86	327086675.00
210101	Үндсэн цалин	192349356.86	326227675.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8142300.00	859000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22076543.14	36034560.00
210201	Тэтгэврийн даатгал	22076543.14	36034560.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34823600.00	32465611.89
210301	Гэрэл, цахилгаан	1929077.00	1220661.00
210302	Түлш, халаалт	29500923.00	28540950.89
210303	Цэвэр, бохир ус	3393600.00	2704000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13952780.00	10933050.00
210401	Бичиг хэрэг	1868150.00	3970490.00
210402	Тээвэр, шатахуун	4344930.50	5544040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7226036.50	1091770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513663.00	326750.00
2105	Нормативт зардал	6355000.00	25000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6355000.00	25000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	565600.00	400000.00
210604	Урсгал засвар	565600.00	400000.00
2107	Томилолт, зочны зардал	1466000.00	1440000.00

210702	Дотоод албан томилолт	1466000.00	1440000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	248880.00	237632.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	100000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88380.00	88400.00
210807	Газрын төлбөр	10500.00	10500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	38732.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38668472.27	36946826.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1105420.00	2191600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200000.00	370000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37363052.27	34385226.53
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400020.00	88.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	400000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20.00	88.11
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20.00	88.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-32040876.86	-28987143.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-32040876.86	-28987143.72

2.17 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

ансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	275690511.69	412833300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11.69	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	11.69	0.00
120009	Бусад орлого	11.69	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275690500.00	412833300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	275690500.00	412233300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	275690500.00	412233300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	600000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	600000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	275690500.00	412272032.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275690500.00	412272032.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275290480.00	409008944.08

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200506000.00	323970000.00
210101	Үндсэн цалин	191623100.00	307660379.00
210102	Нэмэгдэл		6133621.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8882900.00	10176000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22062200.00	35995700.00
210201	Тэтгэврийн даатгал	22062200.00	35995700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34823600.00	32465611.89
210301	Гэрэл, цахилгаан	1929077.00	1220661.00
210302	Түлш, халаалт	29500923.00	28540950.89
210303	Цэвэр, бохир ус	3393600.00	2704000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13058200.00	10950000.00
210401	Бичиг хэрэг	1868150.00	4376490.00
210402	Тээвэр, шатахуун	3450350.50	4735640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7226036.50	1091770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513663.00	746100.00
2105	Нормативт зардал	360000.00	50000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360000.00	50000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	565600.00	500000.00
210604	Урсгал засвар	565600.00	500000.00
2107	Томилолт, зочны зардал	1466000.00	1440000.00
210702	Дотоод албан томилолт	1466000.00	1440000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	248880.00	237632.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		100000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88380.00	88400.00
210807	Газрын төлбөр	10500.00	10500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	38732.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2200000.00	3400000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2000000.00	3000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200000.00	400000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400020.00	3263088.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	400000.00	3263000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400000.00	3263000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20.00	88.11
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20.00	88.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11.69	561267.81
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	600000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	600000.00

2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	600000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	600000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-600000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	11.69	-38732.19
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38720.50	38732.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38732.19	

2.18 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,932,674.00	237,405,912.00	571,602,003.55	1,001,940,589.55
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	192,932,674.00	237,405,912.00	571,602,003.55	1,001,940,589.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,932,674.00	237,405,912.00	571,602,003.55	1,001,940,589.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-28,987,143.72	-28,987,143.72

D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,932,674.00	237,405,912.00	542,614,859.83	972,953,445.83
-----	---------------------------------------	----------------	----------------	----------------	----------------

2.19 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	412233300.00	412271944.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	412233300.00	412271944.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	408970300.00	409008944.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323970000.00	323970000.00
210101	Үндсэн цалин	260476000.00	307660379.00
210102	Нэмэгдэл	44418000.00	6133621.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10176000.00	10176000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8900000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35995700.00	35995700.00
210201	Тэтгэврийн даатгал	21879700.00	35995700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3529000.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2744800.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	784200.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	7058000.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32465700.00	32465611.89
210301	Гэрэл, цахилгаан	2430000.00	1220661.00
210302	Түлш, халаалт	26635700.00	28540950.89
210303	Цэвэр, бохир ус	3400000.00	2704000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10950000.00	10950000.00
210401	Бичиг хэрэг	3950000.00	4376490.00
210402	Тээвэр, шатахуун	4800000.00	4735640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1700000.00	1091770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500000.00	746100.00
2105	Нормативт зардал	50000.00	50000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	50000.00	50000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
2107	Томилолт, зочны зардал	1440000.00	1440000.00
210702	Дотоод албан томилолт	1440000.00	1440000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198900.00	237632.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100000.00	100000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88400.00	88400.00

210807	Газрын төлбөр	10500.00	10500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		38732.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3400000.00	3400000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3000000.00	3000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400000.00	400000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3263000.00	3263000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3263000.00	3263000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3263000.00	3263000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	412233300.00	412233300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	412233300.00	412233300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	412233300.00	412233300.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.0	19.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1.00	1.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	7.00	7.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	2.00	2.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

М.ХУАНГАН

Огноо: 2018.01.30

Х.ЖЕНИСБЕК

Огноо: 2018.01.30

Х.ЕРКЕБУЛАН

Огноо: 2018.01.29